



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 575

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар нийт 19,080.0 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр зохиох ажлын төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах;

2.2. Дүнг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Цолмонд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.2. Тухайн жилийн үр дүн, орлого, зардлын төлөвлөгөөг эдийн засгийн тооцоо судалгаатай төлөвлөж батлуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

3.3. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэж байгаа ажиллагааг таслан зогсоох;

3.4. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн шинэ цогцолборын А, Б блокын барилгын ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй компаниудад гэрээний дагуу алданги ногдуулах, төлүүлэх;

3.5. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 20 дугаар хорооны Сэлхийн зуслангийн Эрхэс сувиллын зориулалттай газар болон газрын баталгаажуулсан хэмжээг тогтоосон шийдвэрт эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй өөрчлөлт оруулсан асуудлыг Сүхбаатар дүүргийн Засаг даргад мэдэгдэж, шийдвэрийг хүчингүй болгох талаар албан шаардлага хүргүүлж холбогдох арга хэмжээ авах;

3.6. Сургуулийн оюутны 1 дүгээр байр нь газар эзэмших эрхийн гэрчилгээгүй байгаа асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

3.7.Төв сургуулийн 17140 м.кв газрын баруун талын хэсэгт байрлах газраас 173.3 м.кв газрыг зөвшөөрөлгүй хашаалсан холбогдох 2 байгууллагад албан шаардлага өгч, газар чөлөөлөлт хийлгэх арга хэмжээ авах;


3.8.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, шалгалтын дүнг Авлигатай тэмцэх газар болон Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт тус тус хүргүүлэхийг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн
17.09.2018 дугаар тогтоолын хавсралт

“Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль” улсын төсөвт үйлдвэрийн газрын
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Үнийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй олж авсан	Захирал, Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн дэд захирал, холбогдох ажиллагсад	8,909.4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авсны дагуу үндсэн хөрөнгө олж авах
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 12, 14, 19, 21, 27, 33, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Захирал, Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн дэд захирал, холбогдох ажиллагсад	10,170.6	Худалдан авах ажиллагааг тооцоо судалгаагаар төлөвлөж, зохион байгуулж, тайлагнах, төлөвлөгөө болон үр дүнг цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлаж байх
Зөрчил, дутагдлын нийт дүн			19,080.0	